



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/98

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Өлзий-Дундговь ХХК-ний агуулахын хашааны урд талд)-т байршилтай Лочингийн Өлзийбат (ЗГ:61010611)-ын амины орон сууцны зориулалттай 120 м.кв (0,01 га) газрыг иргэн Дэлгэрийн Ихбаяр (ЗБ:81071516)-т зориулалтаар нь шилжүүлж 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/209 дүгээр захирамжийн Л.Өлзийбат-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712067 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О БАТ-ЭРДЭНЭ

488190243